

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АЖИЛТНУУДЫН ГҮЙЦЭТГЭХ ЧИГ ҮҮРЭГ**

№	Албан тушаалын нэр	Гүйцэтгэх чиг үүрэг
<b>ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР</b>		
1	Дарга	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ИНЕГ-ын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх замаар байгууллагын бодлого, стратегийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, агентлагийн удирдлагыг үнэн, зөв мэдээлэл, зөвлөгөөгөөр шуурхай хангаж, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх.
2	Ахлах мэргэжилтэн	ИНЕГ-ын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, батлуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах, иргэний нисэхийн салбарын тэргүүлэх стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх нэгдсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх
3	Хүний нөөцийн мэргэжилтэн	Байгууллагын стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн удирдлагатай холбоотой нийтлэг үйлчилгээ, өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, хүний нөөц, хөдөлмөрийн харилцаатай холбоотой аливаа үйл ажиллагааг төлөвлөн шийдвэрлүүлэх, хүний нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэл судалгаа хөтлөх
4	Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	ИНЕГ-ын дотоод ажил, нийтлэг үйлчилгээ, өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах
5	ИНЕГ-ын даргын туслах бөгөөд Өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн	ИНЕГ-ын даргын өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай зохицуулж, ажлаа хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, ажлын цагийг төлөвлөх, зохицуулах, даргын өгсөн үүрэг даалгавар, шийдвэрлүүлэх асуудлыг шуурхай зохион байгуулалтаар хангах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж, тайлагнах
6	ИНЕГ-ын дэд даргын туслах бөгөөд захиргааны мэргэжилтэн	ИНЕГ-ын Дэд даргын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хэвийн ажиллах нөхцөл бололцоог хангах, ИНЕГ-ын Дэд даргаар шийдвэрлүүлэх асуудлыг шуурхай зохион байгуулалтаар хангах, салбарын ахмад настны нийгмийн хамгааллын асуудлыг зохицуулах, ИНЕГ-ын даргын тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
7	Архивын арга зүйч мэргэжилтэн	ИНЕГ, түүний харьяа байгууллагуудын баримт материалыг стандарт, дүрэм, журмын дагуу архивлах, архивын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх
8	Албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн	ИНЕГ-ын албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, зааврын дагуу хөтлөн явуулах, албан хэрэг хөтлөлтийн журам, стандартын мөрдөлтөд хяналт тавих
<b>ДОТООД АУДИТЫН АЛБА</b>		
1	Нисэхийн аюулгүй ажиллагаа хариуцсан менежер	ИНЕГ-ын эрхэм зорилго, стратегийн зорилт, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын хавсралт-19 “Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр”, “Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо”-ны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, удирдамж, зөвлөмжөөр хангах болон нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа, хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтэд чанарын баталгаажуулалт, аудит, дүн шинжилгээ, үнэлгээ хийх замаар үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх
2	Ахлах аудитор, аудитор	Байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хараат бус, бодитой баталгаажуулах ба зөвлөх үйлчилгээ үзүүлэх, эрсдэлийн удирдлага, хяналт, засаглалын үйл явцын үр нөлөөг системтэй, эмх цэгцтэй байдлаар үнэлэх, сайжруулах замаар байгууллагын зорилгодоо хүрэхэд туслах, байгууллага зорилго, зорилгодоо хүрэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцэж буй эсэхийг нягтлан үнэлэх, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх.

3	Хяналт-шинжилгээ, үнэлгээний ахлах мэргэжилтэн	Бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх; Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д заасан этгээдийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, тайлагнах, хянах, хадгалах.
4	Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн	Бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх
<b>САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР</b>		
1	Дарга	ИНЕГ-ын эрхэм зорилго, стратеги зорилт, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд тус газрын болон харьяа байгууллагуудын санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг нэгдсэн бодлого, чиглэл, удирдлагаар хангаж, орлогыг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийг батлагдсан төсвийн дагуу үр ашигтай зарцуулах, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөж, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, санхүү, аж ахуй, нийтлэг үйлчилгээ, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санхүүгийн ерөнхий хяналтыг хэрэгжүүлэх.
2	Ерөнхий хянагч бөгөөд ерөнхий нягтлан бодогч	Иргэний нисэхийн ерөнхий газрын төсвийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх зарцуулалтын үр ашигтай зарцуулах, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, нягтлан бодох бүртгэлийг Олон улсын стандарт холбогдох заавар журамд нийцүүлэн хөтлөх, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр хяналт тавих, анхан шатны баримтын бүрдүүлбэрийг хангаж ажиллах, санхүүгийн нэгтгэсэн тайланг хянаж баталгаажуулах
3	Ахлах мэргэжилтэн	ИНЕГ-ын харьяа үйлдвэрлэлийн алба, салбар нэгжүүдийн төсвийн хөрөнгийг батлагдсан төсвийн дагуу үр ашигтай зохицуулах, батлагдсан орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх, хяналт тавих, удирлагыг санхүүгийн үнэн зөв мэдээллээр түргэн шуурхай хангах, мэдээлэл мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх
4	Тооцооны нягтлан бодогч	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, холбогдох заавар, журмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, Агентлагийн санхүүгийн үйл ажиллагааг мөрдөх, батлагдсан орлого, зардлын төлөвлөгөөг мөрдөж ажиллах,
5	Нярав	ИНЕГ-ын үйл ажиллагааны зорилтуудыг хэрэгжүүлэхэд ажлын хэвийн орчин, нөхцлийг бүрдүүлэх.
<b>ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ДҮРМИЙН БОЛОВСРУУЛАЛТЫН ГАЗАР</b>		
1	Дарга	Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд байгууллагын удирдлагад эрх зүйн дэмжлэг үзүүлэх, олон улсын стандартад нийцсэн дүрэм, журам боловсруулах, тэдгээрт шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах замаар хяналт, зохицуулалтын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг удирдан зохион байгуулах
2	Ахлах мэргэжилтэн	Иргэний нисэхийн ерөнхий газраас боловсруулан гаргаж байгаа эрх зүйн баримт бичгийн үндэслэлийг хянаж хууль тогтоомжид нийцүүлэх, санал өгөх, ажилтнуудад эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх, маргаантай асуудлаар шүүх, хууль хяналтын байгууллагад ИНЕГ-ын эрх ашгийг төлөөлж оролцох, орон тооны бус комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах, газрын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад нэгжийн даргад дэмжлэг үзүүлэх.
3	Хуулийн мэргэжилтэн	Иргэний нисэхийн ерөнхий газраас боловсруулан гаргаж байгаа гэрээ, хэлэлцээр, эрх зүйн баримт бичгийн үндэслэлийг хянаж хууль тогтоомжид нийцүүлэх, санал өгөх, ажилтнуудад эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх, маргаантай асуудлаар шүүх, хууль хяналтын байгууллагад ИНЕГ-ын эрх ашгийг төлөөлж оролцох, орон тооны бус комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах, газрын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад нэгжийн дарга, ахлах мэргэжилтэнд дэмжлэг үзүүлэх.

4	Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	Дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын шуурхай, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын шуурхайн болон тушаалын биелэлт, газрын 7,14 хоногийн тайланг нэгтгэн гаргаж холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлэх, ирсэн явсан албан бичгийг "Албан хэрэг хөтлөх нийтлэг журам"-ын дагуу хөтлөх, Хамтын гэрээ, хэлэлцээрийн биелэлт гаргах, хуулийн этгээд, иргэнтэй байгуулагдах гэрээг хянаж дугаарлаж бүртгэх, хууль шүүхийн байгууллагад итгэмжлэлийн үндсэн дээр байгууллагыг төлөөлөн эрх ашгийг хамгаалах, газрын дотоод асуудалтай холбоотой үйл ажиллагааг хариуцаж, газрын дарга, ахлах мэргэжилтэнд дэмжлэг үзүүлэх
<b>Дүрэм боловсруулалтын тасаг</b>		
1	Дарга	Монгол улсын Иргэний нисэхийн тухай хууль, Иргэний нисэхийн ерөнхий газрын Эрхэм зорилго, стратегийн зорилт болон иргэний нисэхийн зохицуулалтын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд ИНЕГ-ын Дүрмийн боловсруулалтын хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, Монгол улсын Иргэний нисэхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор, Конвенцийн Хавсралтын стандартын минимум, суурь түвшинг хангасан, Монгол улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд тохирсон, хэрэгжүүлэх боломжтой, иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны зохицуулалтын дүрэм, зөвлөмжийн цуврал, маягт болон бүртгэлийн дэвтрийг жишиг-дүрмийн дагуу боловсруулах, тогтмол шинэчлэх.
2	Дүрмийн боловсруулалтын мэргэжилтэн	Конвенцийн Хавсралтуудын стандарт болон жишиг-дүрмийг баримтлан иргэний нисэхийн дүрмийн төсөл боловсруулах, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, иргэний нисэхийн дүрмийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, ИКАО-ын баримт бичгүүдийн (Annex, Doc) нэмэлт, өөрчлөлтүүдийг хүлээн авч холбогдох арга хэмжээ авах.
<b>АГААРЫН ТЭЭВРИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР</b>		
1	Дарга	Агаарын тээврийн зах зээлийг олон улсын туршлага, эдийн засгийн үр өгөөжид тулгуурлан өргөжүүлэх, хамтын ажиллагаа, гэрээ, эрх зүйн орчинг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх, иргэний нисэхийн салбарыг эдийн засгийн үр ашигтай өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх
2	Агаарын харилцааны тасгийн дарга	Агаарын тээврийн зах зээлийг олон улсын туршлага, эдийн засгийн үр өгөөжид тулгуурлан өргөжүүлэх, хамтын ажиллагаа, гэрээ эрх зүйн орчинг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх
3	Агаарын харилцааны ахлах мэргэжилтэн, Агаарын харилцааны мэргэжилтэн, Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, ИКАО, олон улсын байгууллага хариуцсан мэргэжилтэн	Агаарын тээврийн зах зээлийг олон улсын туршлага, эдийн засгийн үр өгөөжид тулгуурлан өргөжүүлэх, хамтын ажиллагаа, гэрээ эрх зүйн орчинг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
4	Эдийн засгийн зохицуулалтын тасгийн дарга	Иргэний нисэхийн салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах
5	Эдийн засгийн зохицуулалтын ахлах мэргэжилтэн, эдийн засагч, агаарын тээврийн мэргэжилтэн	Иргэний нисэхийн салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
<b>АГААРЫН НАВИГАЦИ, НИСЭХ БУУДЛЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР</b>		
1	Дарга	Иргэний нисэхийн салбарт үзүүлэх агаарын навигаци, нисэх буудлын үйлчилгээнүүдийн бодлого, чиглэлийг тодорхойлох, удирдлагад мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллах
2	Ерөнхий менежер	Агаарын навигаци, нисэх буудлуудын үйлчилгээг Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын бодлого, зөвлөмжид нийцүүлэн хөгжүүлэх ойрын болон хэтийн чиг хандлагыг тодорхойлох, эрх зүйн баримт бичгийг боловсруулахад чиглэл өгөх,

		хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, биелэлийг хангуулах
3	Агаарын навигаци хариуцсан менежер	Иргэний нисэхийн салбарт үзүүлэх Агаарын навигацийн үйлчилгээний бодлого, чиглэлийг тодорхойлох, агаарын навигацийн үйлчилгээний стратегийн төлөвлөлтийг боловруулах, стратегийн төлөвлөлтийн хэрэгжилтийн талаар нэгдсэн тайлан боловсруулах
4	Нисэх буудал хариуцсан менежер	Олон улсын болон орон нутгийн нисэх буудлын бодлогын хэтийн төлөв, стратегийг тодорхойлох, боловрсонгуй болгох, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын жишиг, стандарт шаардлагын түвшинд нийцүүлэн бодлогын чиглэлээр хангаж ажиллах
5	Аюулгүй байдлын мэргэжилтэн	Иргэний нисэхийн үйл ажиллагааг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах, эрх зүйн болон үйл ажиллагааны орчинг бүрдүүлэх чиглэлээр бодлогын санал боловсруулах, эрх зүйн болон удирдлагын баримт бичгүүдийн шинэчлэлт, нэмэлт өөрчлөлтөд санал оруулах, Иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, нэмэлт өөрчлөлт шинэчлэн боловсруулалтад мэргэжлийн зөвлөмж, дүгнэлт гаргах, стандартчиллын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэхэд оролцох
6	Аэродромын мэргэжилтэн	Иргэний нисэхийн зориулалттай нисэх буудлын аэродромын ерөнхий төлөвлөлт, бодлогыг боловсруулах, тэдгээрийн ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих, аэродромын стандартчлалын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, зохицуулах, мэргэжлийн дүгнэлт гаргах, түүнд тохирох арга хэмжээг авч ажиллах
7	Нислэгийн хөдөлгөөний менежментийн мэргэжилтэн	Иргэний нисэхийн салбарт үзүүлэх нислэгийн хөдөлгөөний агаарын зайн зохион байгуулалт, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн бодлого, чиглэлийг тодорхойлох, хариуцан ажиллах чиглэл, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах, мэргэжилтнүүдэд дэмжлэг тусалцаа үзүүлэх.
8	Техникийн бодлого хариуцсан мэргэжилтэн	Иргэний нисэхийн салбарт үзүүлэх Агаарын навигацийн техник технологийн бодлого тодорхойлох, түүнийг хянах, хэрэгжүүлэлтийг хангахтай холбоотой бодлого, чиглэлийг тодорхойлох, хариуцан ажиллах чиглэл, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах, мэргэжилтнүүдэд мэргэжлийн дэмжлэг тусалцаа үзүүлэх,
<b>ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭЛТЭС</b>		
1	Хэлтсийн дарга	Монгол Улсын Иргэний нисэхийн салбарыг үндэсний хөгжлийн бодлого, Олон улсын чиг хандлагатай уялдуулан шинэчлэн хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг зохион байгуулах, мөн инновацийн хөгжлийн бодлого болон ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх, хэрэгжилтийг хангуулах
2	Ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн	Монгол Улсын Иргэний нисэхийн салбарыг үндэсний хөгжлийн бодлого, Олон улсын чиг хандлагатай уялдуулан шинэчлэн хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг зохион байгуулах, мөн инновацийн хөгжлийн бодлого болон ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх, хэрэгжилтийг хангуулах
<b>НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБА</b>		
1	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах
2	Менежер	НААХЗА-ны зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд ИНЕГ-ын дэд дарга бөгөөд Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны даргад дэмжлэг үзүүлэх, нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж ажиллах.
3	Аюулгүй ажиллагааны дотоод хяналт хариуцсан менежер	ИНЕГ-ын эрхэм зорилго, стратегийн зорилт, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын Хавсралт 19 “Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр”, “Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо”-ны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, удирдамж, зөвлөмжөөр хангах болон нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа, хууль, тогтоомж, стандарт, дүрэм,

		журмын хэрэгжилтэд чанарын баталгаажуулалт, аудит, дүн шинжилгээ, үнэлгээ хийх замаар үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх
<b>НИСЛЭГИЙН СТАНДАРТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫН ХЭЛТЭС</b>		
1	Хэлтсийн дарга бөгөөд нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч	Нислэгийн стандарт, үйл ажиллагаанд ИНЕГ-ын даргаас шилжигдсэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль, Иргэний нисэхийн холбогдох багц дүрмийн хэрэгжилтийг хянан бататгахад хэлтсийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, бусад хэлтэстэй хамтын ажиллагааг хангах.
2	Газрын үйл ажиллагаа хариуцсан ахлах байцаагч	Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн (газрын үйл ажиллагаа, аюултай бараа тээвэрлэлт) чиглэлийн дагуу дэмжлэг үзүүлэх
3	Нислэгийн стандарт хариуцсан ахлах байцаагч	Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн (нислэгийн үйл ажиллагаа) чиглэлийн дагуу дэмжлэг үзүүлэх
4	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч /газрын үйл ажиллагаа хариуцсан/	Иргэний нисэхийн үйл ажиллагаанд хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн (агаарын тээвэрлэгчийн газрын үйл ажиллагаа) чиглэлийн дагуу дэмжлэг үзүүлэх
5	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч /аюулгүй ажиллагаа хариуцсан/	Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн (агаарын тээвэрлэгчийн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо) чиглэлийн дагуу дэмжлэг үзүүлэх.
6	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч /нислэгийн хяналт зохицуулалт хариуцсан/	Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн чиглэлийн дагуу дэмжлэг үзүүлэх.
7	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч /бүхээгийн үйл ажиллагаа хариуцсан/	Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн /агаарын тээвэрлэгчдийн бүхээгийн үйл ажиллагаа / чиглэлийн дагуу дэмжлэг үзүүлэх.
8	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч /дотоод хяналт/	Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн (байгууллагын чанар дотоод хяналтын тогтолцоо) чиглэлийн дагуу дэмжлэг үзүүлэх.
9	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч	Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн (Нислэгийн үйл ажиллагаа болон агаарын хөлгийн ашиглалт) чиглэлийн дагуу дэмжлэг үзүүлэх
10	Мэргэжилтэн	Хэлтэст хөтлөгдөж буй албан хэргийг зааврын дагуу хөтлөх, хэлтсийн хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах техник ажиллагааг гүйцэтгэх, баримт бичгүүдийн хадгалалт ашиглалтыг хариуцах.
<b>ҮНЭМЛЭХ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТИЙН ХЭЛТЭС</b>		
1	Хэлтсийн дарга бөгөөд нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч	Иргэний нисэхийн тухай хууль, ИНД-61,63,65,66,67,141-ийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, нислэгийн аюулгүй ажиллагааг хангах
2	Нисэх бүрэлдэхүүн хариуцсан ахлах байцаагч	Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор үнэмлэхжүүлэлт, гэрчилгээжүүлэлтийн хяналт тавих
3	Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч /нислэгийн хөдөлгөөний/	Иргэний нисэхийн тухай хууль, ИНД-65 дүрмийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих
4	Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч /эрүүл мэндийн/	Иргэний нисэхийн тухай хууль, ИНД-67 дүрмийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих

5	Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч	Иргэний нисэхийн тухай хууль, ИНД-66 дүрмийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих
6	Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч /сэтгэл зүйч/	Иргэний нисэхийн тухай хууль, ИНД-67 дүрмийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих
7	Мэргэжилтэн	Нисэхийн мэргэжлийн үнэмлэх эзэмшигчдийн бүртгэл /программ/ хөтлөх, хувийн хэргийг хадгалах, архивлах, хэлтсийн албан хэргийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу хөтлөх
<b>НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАРЫН ХЭЛТЭС</b>		
1	Хэлтсийн дарга бөгөөд нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч	Иргэний нисэхийн зориулалтаар нислэг үйлдэх Монгол Улсад бүртгэлтэй болон Чикагогийн конвенцийн хавсралт 83 bis гэрээний дагуу гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгүүдийн нислэгт тэнцэх чадварын хадгалалтанд тавих хяналтыг зохион байгуулах. Агаарын хөлөгт техник үйлчилгээг гүйцэтгэх байгууллага, нисэхийн хангамжийн байгууллагууд нь ИКАО-ын стандарт болон иргэний нисэхийн тухай Монгол улсын хууль, ИНБД, холбогдох стандарт шаардлагуудад нийцсэн эсэхэд мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.
2	Нислэгт тэнцэх чадварын хяналтын ахлах байцаагч	Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх
3	Техник үйлчилгээний байгууллага хариуцсан ахлах байцаагч	Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх
4	Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч	ИНД-144 болон холбогдох стандарт шаардлагын дагуу Нисэхийн хангамжийн байгууллагын үйл ажиллагаанд аюулгүй ажиллагааны хяналт тавих
5	Байцаагч /Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналтын/	Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх
6	Мэргэжилтэн	Иргэний нисэхэд үйл ажиллагаа явуулж буй байгууллага, хувь хүн, агаарын хөлөг Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль, иргэний нисэхийн багц дүрмүүд, үйл ажиллагааны зааврууд, журмын мөрдөлт, хэрэгжилтэнд хяналт тавих ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хэлтсийн байцаагч нарын дотоод үйл ажиллагааны уялдаа холбоог хадгалах зорилгоор хэлтсийн үндсэн үүрэгтэй холбогдсон техник үйл ажиллагааг гүйцэтгэх, хэлтсийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа баримт бичиг, гэрчилгээ зөвшөөрлийг бүртгэх, түгээх, тайлан төлөвлөгөө, судалгаа хийх.
<b>АЭРОДРОМ, АГААРЫН НАВИГАЦИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТЭС</b>		
1	Хэлтсийн дарга бөгөөд нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч	Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль болон ИНЕГ-ын даргаас шилжүүлсэн эрх, үүргийн хүрээнд ИНД 71, 73, 75, 77, 95, 108, 109, 138, 157, 191, 139, 140, 171, 172, 173, 174, 175-ын дагуу иргэний нисэхийн аэродром, агаарын навигацийн хангалт, үйлчилгээ, нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангуулахад чиглэсэн мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
2	Агаарын навигацийн үйлчилгээ хариуцсан ахлах байцаагч	ИНД-171-ийн дагуу гэрчилгээжсэн Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын үйл ажиллагаанд Иргэний нисэхийн тухай Монгол улсын хууль, ИНБД, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бататгах, аюулгүй ажиллагааг хангуулах, байнгын хяналт тавих.
3	Аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагч	Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны стратеги зорилтыг хангах зорилгоор мэргэжлийн чиглэлийн дагуу дэмжлэг үзүүлэх
4	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч /нислэгийн	ИНД-172-ын дагуу гэрчилгээжсэн Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд Иргэний нисэхийн тухай хууль, ИНД-71, 73, 75-ын хэрэгжилтийг хангуулах зорилгоор гэрчилгээжүүлэлт, аудит, үзлэг шалгалтын хэлбэрээр байнгын

	хөдөлгөөний үйлчилгээ хариуцсан/	хяналт тавих, ИНД-138-ын дагуу Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын Эрэн хайх, авран зохицуулах төвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, заавар журмын хэрэгжилтийг шалгах, бататгах, хяналт тавих, үзлэг, шалгалт хийх.
5	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч /аэродром хариуцсан/	Иргэний Нисэхийн тухай Монгол Улсын хууль, ИНД-139, ИНД-157-ийн хүрээнд иргэний нисэхийн аэродром, нисэх буудал байгуулах, ашиглахтай холбоотой асуудлаар санал дүгнэлт гаргах, гэрчилгээжсэн аэродромд аюулгүй ажиллагааны байнгын хяналт тавих, иргэний нисэхийн аэродромуудыг гэрчилгээжүүлэх, зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд аудит шалгалт хийх, аэродромын үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэх, зогсоход мэргэжлийн дүгнэлт гаргах, аэродромтой холбоотой аливаа зөрчил, дутагдлын шалтгаанд дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулах
6	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч /аэродром хариуцсан/	Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль, ИНД-139, ИНД-157-ийн хүрээнд иргэний нисэхийн аэродром, нисэх буудал байгуулах, ашиглахтай холбоотой асуудлаар санал дүгнэлт гаргах, гэрчилгээжсэн аэродромд аюулгүй ажиллагааны байнгын хяналт тавих, иргэний нисэхийн аэродромуудыг гэрчилгээжүүлэх, зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд аудит шалгалт хийх, аэродромын үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэх, зогсоход мэргэжлийн дүгнэлт гаргах, аэродромтой холбоотой аливаа зөрчил, дутагдлын шалтгаанд дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулах
7	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч /нисэхийн цаг уурын үйлчилгээ хариуцсан/	Нисэхийн цаг уурын үйлчилгээ эрхлэх байгууллагыг Иргэний нисэхийн тухай хууль, ИНД-174-ийн дагуу гэрчилгээжүүлэх үзлэг шалгалт хийх, дүгнэлт гаргаж, шаардлага зөвлөмж хүргүүлэх, Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/, Дэлхийн цаг уурын байгууллага /WMO/-ын стандарт зөвлөмжүүдэд нийцүүлэн гаргасан заавар, журмын хэрэгжилт болон нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, үзлэг шалгалт хийж дүгнэлт гаргах.
8	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч /нислэгийн журмын үйлчилгээ хариуцсан/	ИНД-173-ын дагуу гэрчилгээжсэн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагад иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдлыг хангуулах, Иргэний нисэхийн зохицуулалт, стандартын хэрэгжилтийг бататгах үүднээс ИНД-12, 71, 73, 75, 77, 91, 95, 121, 135-ыг тус тус мөрдлөг болгон мэргэжлийн хяналт тавих, үзлэг шалгалт хийх, “Шалгалтын нислэгт тавигдах шаардлага” баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт тавих.
9	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч /нисэхийн мэдээллийн үйлчилгээ хариуцсан/	ИНД-175-ын дагуу гэрчилгээжсэн Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль, ИНБД, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бататгах, аюулгүй ажиллагааг хангуулах талаар байнгын хяналт тавих
10	Аюулгүй байдлын мэргэжилтэн	Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны стратеги зорилтыг хангах зорилгоор мэргэжлийн чиглэлийн дагуу хэлтсийн даргад дэмжлэг үзүүлэх